

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/258 дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2023 он

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Тендер
шалгаруулалтын
дугаар:

Мэс заслын тоног төхөөрөмж худалдан авах

ГССҮТ/20240202014

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Сонирхогч этгээд, оролцогч	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	3
11. Тендерийн иж бүрдэл.....	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	5
13. Хувилбарт санал.....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	8
20. Тендерийн валют.....	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа	9
22. Тендерийн баталгаа	9
23. Тендер баталгаажуулах, илгээх	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	10
25. Тендерийн талаар тодруулга авах	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох.....	11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	11
32. Тендерийг эрэмбэлэх	11

33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	11
34.	Мэдэгдэл хүргүүлэх	11
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	12
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	12

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|--|---|
| 1. Тендерийн цар хүрээ | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| 3. Худалдан авах ажиллагааны тогтоомж | 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ. |
| 4. Худалдан авах ажиллагааны систем | 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана. |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өргтийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна. |
| | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч** **этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Б.АГУУЛГА

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
 - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
 - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
 - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
 - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
 - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- B. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зэрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
 - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
 - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
 - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
 - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- | | | |
|---|---|---|
| 14. Тендерийн маягтууд | жишиг
15. Хувилбарт санал | 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ. |
| 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг | 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно. | |
| 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг баримт бичиг | 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маят 1-ийн дагуу ирүүлнэ.
16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална. | |
| 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг баримт бичиг | 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маят 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй. | |

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээллэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсэн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 21.10. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 21.11. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 21.12. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 21.13. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 21.14. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.15. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 21.16. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 21.17. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 21.18. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маят 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Давуу эрх олгох		31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт		31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцгчийн ирүүлсэн тендэрээс татгалзах үндэслэл болохгүй.
33. Тендерийн харьцуулах тодорхойлох	үнийг	31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
34. Тендерийг эрэмбэлэх		32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
35. Оролцгчийн чадавхыг магадлах	дахин	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үндсэн журмыг баримтална. 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцгчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцгчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ		
36. Шийдвэр хүргүүлэх		36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <i>Гэмтэл согог судлалын үндэсний төв</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>Мэс заслын тоноог төхөөрөмж худалдан авах</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ГССҮТ/20240202014
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: Зөөврийн диализын аппарат, ус цэвэршүүлэгч аппаратын хамт</i> <i>Багц № 2: Унтуулгын аппарат</i> <i>Багц № 3: Өвчтөний хяналтын монитор</i> <i>Багц № 4: Мэс заслын ор</i> <i>Багц №5: Микроскоп</i> <i>Багц №6: Коагуляци</i>
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: Байхгүй
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үзүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт-урсгал төсөөв</i>
ТШЗ 2.1	Нийт төсөөвт өртөг: 792,000,000 <i>Багц № 1: 120,000,000</i> <i>Багц № 2: 366,000,000</i> <i>Багц № 3: 153,700,000</i> <i>Багц № 4: 24,000,000</i> <i>Багц № 5: 98,300,000</i> <i>Багц № 6: 30,000,000</i>
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:

	<p>Хүлээн авагчийн нэр: Үйл Ажиллагаа Хариуцсан Дэд Захирал Б.Батзориг</p> <p>Хаяг: УБ хот, Баянгол дүүрэг, 31-р хороо, өөрийн байр, 1 давхар, Санхүү бүртгэлийн алба 135 тоот</p> <p>Утасны дугаар: факс-70180136, 99167515, 89999574</p> <p>Цахим шуудангийн хаяг: ntorc@gemtel.mn, вэб хуудас: gemtel.mn</p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1	-Оролцогч Хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн /Маягт1/-ийн дагуу, мөн санал болгож буй барааны үнийн задаргааг /Маягт2/-ын дагуу гаргаж, техникийн тодорхойлолт, бараа нийлүүлэлтийн хуваарийг тус тус баталгаажуулан ирүүлнэ.
ТШЗ 16.2	<ul style="list-style-type: none"> - Тендер нээсэн өдрөөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн /tender.gov.mn/ лавлагаа хэсэг рүү орж шалгахад өр төлбөргүй байх /Татварт өртэй байвал тус тендерээс татгалзах үндэслэл болно -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт -Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолтын /tender.gov.mn/ Лавлагаа хэсгээс татаж үзнэ.
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “үгүй”
ТШЗ 17.5	Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
ТШЗ 17.6	<p>Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Шаардана”</p> <p>Баталгаат хугацааны туршид шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, үнийн мэдээлэл ирүүлнэ. Баталгаат хугацаа 2 жил ба түүнээс дээш жил</p>

	<p>Баталгаат хугацаа дуусснаас хойш нийлүүлсэн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцан хийх чадвар, туршлагатай байх</p>
ТШЗ 18.1	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”</p> <p>-Тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулж, тохируулах, сургалт явуулах. Баталгаат хугацаанд засвар үйлчилгээ хийх инженер техникийн ажилтны мэдээлэл ирүүлэх</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай”</p> <p>Сүүлийн 2 жил төсөөт өртгийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь 1 удаа ажилласан байна. Ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолт эсвэл захиалагчийн дүгнэлтийг ирүүлнэ.</p> <p>- Тухайн тоног төхөөрөмжийн сервис үйлчилгээг өмнө нь гүйцэтгэж байсан туршлагатай бол давуу тал болно.</p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана”</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жилийн /2022, 2023 он/ борлуулалтын орлогын дундаж нь нийт төсөөт өртгийн 80%-иас дээш байна.</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй тухайн багцын дүнгийн 80 хувиас багагүй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогч нь татварын ерөнхий газар, харилцагч банкнаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлэх - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх - Нийлүүлэх барааны тоо хэмжээг маягтын дагуу ирүүлэх <p>Дээрх тодорхойлтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</p>
ТШЗ 18.2	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл:</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын техникийн комиссын урьдчилсан дүгнэлт
ТШЗ 19.1	Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”

	<ul style="list-style-type: none"> - Харилцагч банкны тодорхойлолт; (Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ) - Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа; <p>Тендер нээсэн өдрөөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн /tender.gov.mn/ лавлагаа хэсэг рүү орж шалгахад өр төлбөргүй байх /Татварт өртэй байвал тус тендерээс татгалзах үндэслэл болно/</p> <ul style="list-style-type: none"> - сүүлийн хоёр хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан; - сүүлийн хоёр хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. -санхүүгийн тайланда аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланда хийсэн аудитын дүгнэлт.] <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 оны</p>
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм</p> <p>-Санал болгож буй барааны үнийн задаргааг /Маягт2-/ын дагуу гаргаж, техникийн тодорхойлолт, бараа нийлүүлэлтийн хуваарийг тус тус баталгаажуулан ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - техникийн чадавх болон туршлагын талаар Хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5 -д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлох баримт. - оролцогчийн туршлагыг харуулах Өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 3, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p>
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм” “Incoterms 2020” DDP гарах бүх зардлыг нийлүүлэгч тал хариуцана.
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн:</p> <p>Багц № 1: 600,000</p> <p>Багц №2: 1,830,000</p>

	<p>Багц№3: 768,500</p> <p>Багц№6: 491,500</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох баримт бичиг, материалыг нууцлахгүй ирүүлнэ. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ.</p>
ТШЗ 26.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 05 сарын 31 -ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 05 дугаар сарын 31 -ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 30 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: УБ хот, Баянгол дүүрэг, 31-р хороо Далив хутагт Жамсранжавын гудамж, Гэмтэл согог судлалын үндэсний төв</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар, сургалтын өрөө,</p>
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: байхгүй
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглахгүй”
ТШЗ 37.1	Хуулийн 42.1-д заасны дагуу 100 саяас дээш төгрөгийн гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшигүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

1. Зөөврийн диализын аппарат, ус цэвэршүүлэгчийн хамт

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөөхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Диализын машин <ul style="list-style-type: none"> Эмчилгээний чанар, аюулгүй байдлыг хангасан, найдвартай, ашиглахад хялбар 10.4" өнгөт эргүүлэх боломжтой мэдрэгчтэй дэлгэцтэй Автомат праймер /дахин халдвартгүйжүүлэх 		
2	ҮЗҮҮЛЭЛТҮҮД Хэмжээ:300(W)x460(D)x1480(H) 100кг Жин:100 Цахилгаан хангамж <ul style="list-style-type: none"> AC220V/230V/110V ±10% Max. Хэрэглээ: 110V үед 1650VA 230V үед 2500VA Усан хангамж <ul style="list-style-type: none"> Температур: 15-30°C 0-30°C /нэмэлт дулаан солицууртай үед/ Даралт: 0,05-0,74MPa Ургалын хэмжээ: 900ml ба түүнээс илүү Чанар: ISO13959:2009 Функции <ul style="list-style-type: none"> Ацетат ба бикорбонат диализ Ультрафильтраци Нэг зүү эмчилгээ /нэг зүү насос/ Ультрафильтрацийн профайл Концентрацын профайл 10.4 "өнгөт мэдрэгчтэй дэлгэц Kt/V(тооцоолуур) Батарей Халуун цэвэрлэгээ Хуурай сод /B-Powder/ - /нэмэлт/ Онлайн НДФ /HDF/ /нэмэлт/ A/B концентрацийн төв систем /Нэмэлт/ Автоматаар салгах /Reinfusion/ 		
3	УФ-ын хяналт <ul style="list-style-type: none"> Эзэлхүүний хяналт УФ хэмжээ:0,0.10-5.0л/цаг Нарийчлал: ±30гр/цаг Бикорбонат диализ: <ul style="list-style-type: none"> Ус+B : 24-70ммоль/л 		

	<p>(Байгалийн электролитийн концентраци)</p> <ul style="list-style-type: none"> Ус+А+В :125-165ммоль/л (Na⁺ электролитийн концентраци) <p>Ацетат диализ:</p> <ul style="list-style-type: none"> Ус+А :125-165ммоль/л (Na⁺ электролитийн концентраци) <p>Диализын урсгалын хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> 100-800мл/мин <p>Диализын урсгалын хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> 33,0°C-39,0°C <p>Артерын цусны шахуурганы урсгалын хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> 0,10-600мл/мин <p>Гепаринны шахуурга</p> <ul style="list-style-type: none"> Нийт хэмжээ: 0,0-20мл Шахах хэмжээ: 0,5-5,0мл Тариурын хэмжээ: 10,20,30мл Зогсоох програмтай 		
4	<p>Агаар мэдрэгч</p> <ul style="list-style-type: none"> Ультрасоник мэдрэгч Хамгийн бага мэдрэх агаар: 0,3μL Өгөгдсөн хэмжээ: 3 шаталтай-1 μL/50 μL/100 μL <p>Венийн даралтын хяналт</p> <ul style="list-style-type: none"> -500-500мм <p>Артерын даралтын хяналт</p> <ul style="list-style-type: none"> -500-500мм <p>Зайлалтын программ</p> <ul style="list-style-type: none"> Усан зайлалт Химийн цэвэрлэгээ / гидохлорид/ Халуун зайлалт / 80°C хүртэл, нимбэгний хүчил/ Хүчлийн зайлалт / цууны хүчил/ 		
5	<p>Нэмэлт:</p> <ul style="list-style-type: none"> Цусны даралтыг хянах боломжтой Төвийн системээс А/B уусмалаа хангах LAN -гийн холбогчтой Дулаан солилцууртай CF нээлт хэсэгтэй Диализат болон цэвэрлэгээний уусмалын тавиуртай Автоматаар шингэн гүйлгэх болон салгах горимтой Өвчтөний карт/ сүлжээнд холбогдох боломжтой Онлайн HDF/ үйлдвэрээс нэмэлтээр суурилуулсан Шингэний түвшинг тохируулагчтай Хуурай сод/ B-powder / нэмэлт 		
6	NCU-18 - тай дүйцэхүйц		
7	<p>Усны систем</p> <p>Хэмжээ:480 x 170 x 360 мм 35 кг</p> <p>Жин: 35кг</p>		

	<p>Диализийн ус үйлдвэрлэх хамгийн дээд хүчин чадал нь 10°C, арын даралт 2.5 br</p> <p>-02HR03002 701/цаг -02HR03110 501/цаг -02HR03111 761/цаг</p> <p>Диализийн усны даралт: 3br</p> <p>Мембран сулрах хурд: 95%</p> <p>Ус тэжээх: Хоолой DNB</p> <p>Диализийн ус: Hase DN 6 (2x 1.5 м)</p> <p>Цахилгааны залгуур: 220 V-хувилбар: СЕЕ 7/7</p> <p>Нийлүүлэлтийн хүчдэл: 230В/50-60 Гц</p> <p>Энерги зарцуулалт: хамгийн их. 0.3 кВт</p> <p>Дамжуулах чадвар: 2000 мкС/см</p> <p>Температур хүрээ: 5-25 хэм</p> <p>pH-утга: 6.5-8.5</p> <p>Агаар чийгшил: хамгийн их. 90% чийгшил, конденсацигүй</p> <p>Төмөр: 0.05 мг/л</p> <p>Гал хамгаалагч: 16 A/FI AI 30 mA</p> <p>Аюулгүй байдлын зэрэг: 1</p> <p>хэт хүчдэлийн ангилал: 2</p> <p>SDI: <3</p> <p>Чөлөөт хлор: 0.10 мг/л</p> <p>Суурилуулалтын өндөр: NHN-ээс дээш хамгийн ихдээ 2000 м</p> <p>Тусгаарлах усан хангамж: 2.5-6 бар</p> <p>Ус зайлзуулах мак: Нэгжийн дээд ирмэгээс дээш 100 см</p>	
8	NIPRO HemoRo 3000 -тай дүйцэхүйц	
9	Баталгаат хугацаа 2 ба түүнээс дээш жил	

2. Унтуулгын аппарат

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	<p>Цахилгааны зарцуулалт<95 Вт, механик хиймэл амьсгалын үед, хамгийн ихдээ 400 Вт</p> <p>Үндсэн хүчдэл 100 – 240 В Хувьсах 50/60 Гц</p> <p>Цахилгааны зарцуулалт хамгийн ихдээ 4А</p> <p>Баттерейгаар ажиллах хугацаа Хамгийн багадаа 60 мин болон түүнээс дээш байх</p> <p>Температур 10 -40 °C (50 to 104 °F)</p> <p>Орчны даралт 650 – 1,060 hPa (далайн түвшнээс дээш 3500 метрийн өндөрт тохирсон</p> <p>Хийн хангамж</p> <p>(O2/AIR/N2O), электроник хэмжилт ба холбогдсон бүх хийн хангамжийг хянадаг байх.</p> <p>Стандарт хиймэл амьсгалын горим</p> <ul style="list-style-type: none"> Гар аргаар /Албадмал (Man/Spon) Эзлэхүүний удирдлагатай: хугацааны удирдлагатай (VC-CMV) Даралтын удирдлагатай: хугацааны удирдлагатай (PC-CMV) 		
2	<p>Нэмэлт хиймэл амьсгалын горимууд (сонголтоор)</p> <ul style="list-style-type: none"> AutoFlow хугацааны удирдлагатай (VC-CMV/AF) Эзлэхүүний удирдлагатай, синхрончлогдсон (VC-SIMV) Даралтын удирдлагатай, синхрончлогдсон (PC-SIMV) AutoFlow, синхрончлогдсон (VC-SIMV/AF) CPAP / PSV Нэмэлт цэвэр хийн outlet-тай 		
3	<p>Амьсгалын давтамж (RR) 3 - 100 /мин</p> <p>Амьсгал авалтын хугацаа (Ti) 0.2 -10 s</p> <p>Амьсгал авалт/гаргалтын харьцаа (I:E) 1:50 - 50:1</p> <p>Түрлэгийн эзлэхүүн(VT)</p> <p>10 - 1,500 мл</p> <p>5 -1,500 мл нярай хүүхдэд зориулсан сонголттой</p> <p>Триггер хийх босго утга (Trigger) 0.3 - 15 л/мин</p> <p>Амьсгал авалтын урсгал (Flow) Хамгийн багадаа 0.1 л/мин, хамгийн ихдээ ≥160 л/мин</p> <p>Амьсгал авах үеийн даралт (Pinsp) PEEP +5 to 80 hPa (cmH2O)</p> <p>Даралтын хязгаар (Pmax) PEEP +10 to 80 hPa (cmH2O) PEEP</p> <p>даралтын дэмжлэг (Δpsupp) Off, 3 - (80 - PEEP) hPa (cmH2O)</p>		

4	<p>Амьсгалын систем: Ариутгаж дахин ашиглах боломжтой байх</p> <p>Шингээгчийн эзлэхүүн Ойролцоогоор 1.2 -1.5 л Дахин ашиглах Цэвэрлэх, халдвартгуйжүүлэх, солиход нэмэлт багаж шаардлагагүй, дахин ашиглах боломжтой</p> <p>Идэвхтэй мэдээгүйжүүлгийн хийн хаягдал гадагшлуулах систем Мэдээгүйжүүлгийн хийн хаягдал гадагшлуулах системтэй холбогдоно. Хавхлагын удирдлагатай (сонголтоор) ejector-той (сонголтоор)</p> <p>Хэмжилтийн систем ба дэлгэц</p> <p>Дэлгэц 15.3" (38.9 см) мэдрэгч дэлгэцтэй, дэлгэцэн дээрх агуултыг өөрчлөх боломжтой байх</p>		
5	<p>Дэлгэцийн тохиргоо</p> <p>CO₂, O₂ ба мэдээгүйжүүлгийн агент, агаарын даралт, амьсгал авалт/ гаргалтын урсгал зэрэг мэдээллийг аппаратны тохиргоноос хамаарч нэгэн зэрэг 2, 3 эсвэл 4 бодит хугацааны муруйг дэлгэцэнд харуулдаг. O₂, AIR, N₂O-н виртуал урсгалын хоолой, түргэн хугацаанд хандалт хийх боломжтой дэлгэцийн 3 давхаргатай байх</p> <p>Аппаратны статусыг дэлгэцэнд гаргах</p> <p>Агаарын даралт, баттерей болон хийн хангамжийн мэдээллийг урд панелын LC дэлгэцэнд харуулна. (CGS + цилиндр)</p>		
6	<p>Хиймэл амьсгалын хяналт</p> <p>Минутын эзлэхүүн (MV) түрлэгийн эзлэхүүн (VT ба ΔVT); амьсгалын давтамж (давтамж); амьсгал авалтын даралтын хязгаар (PIP), plateau даралт (Pplat), дундаж агаарын даралт (Pmean), PEEP; динамик комплианс (Cdyn), эсэргүүцэл (R), elastance (E), pressure gauge нь дотоод амьсгалын системийн даралтын хэмжээг заадаг</p> <p>Хиймэл амьсгалыг хянах (Сонголтоор)</p> <p>Эзлэхүүн болон түрлэгийн эзлэхүүний бар диаграм, Эзлэхүүн даралттай болон урсгалын даралттай loop-г нэгэн зэрэг дэлгэцэнд харуулдаг</p> <p>Хийн хяналт</p> <p>Аппарат нь амьсгал авалтын O₂-н концентрацийг хянадаг ба O₂, N₂O ба мэдээгүйжүүлгийн агент-г хянахад нэгтгэсэн өвчтөний gas хэмжилтийн модулыг ашигладаг.</p>		
7	<p>Өвчтөний газ хэмжилтийн модуль</p> <p>O₂, N₂O, CO₂-н амьсгал авалт/гаргалтын хийн концентраци, мэдээгүйжүүлгийн агент, мэдээ алдуулгын эмийг автоматаар ялан таних, унтуулгын хийг илрүүлэх боломжтой байх.</p>		
8	<p>Амьсгал авалтын O₂ sensor cell-тэй хувилбар</p> <p>Хамгийн багадаа 2 жил ажиллах баталгаат хугацаатай O₂ sensor cell</p>		
9	<p>Бусад онцлог шинжүүд</p> <ul style="list-style-type: none"> – Автоматаар асааж, бүх сенсоруудыг калибрөвк хийж, хяналтын бүх хавхлагуудыг шалгаж ажиллагаа хэвийн байгаа эсэхийг шалгадаг; 		

	<p>хэрэглэгчийн зүгээс ямар нэг үйлдэл хийх шаардлагагүй</p> <ul style="list-style-type: none"> - Дохиоллын бүх хязгаарыг автоматаар тохируулах функцтэй СВМ горим(cardiac bypass mode) - Цэвэр хийн дутагдал алдагдлын үед амьсгалын уутаар нь илрүүлэх боломжтой - Бодино хугацаанд амьсгал тасалдаад түр завсарлах горимтой - USB-д мэдээллийг хадгалдаг - Тоормозтой дугуйтай 		
10	Dräger Atlan /A300 XL марктай дүйцэхүйц байх		
11	<ul style="list-style-type: none"> • Баталгаат хугацаа: 2 ба түүнээс дээш жил 		

3-1. Өвчтөний хяналтын монитор WiFi, +Central system

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрэвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	Санал болгож буй техникийн тодорхойлолт <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	Тайлбар <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
1	Шаардлагатай үзүүлэлт: <ul style="list-style-type: none"> • Дэлгэц: 12" болон түүнээс дээш 800x600 нарийвчлалтай өнгөт TFT LCD мэдрэгч дэлгэцтэй байх • Дэлгэцэнд 8 хүртэлх долгионы мэдээллийг үзүүлдэг байх • Параметрүүд: ECG (HR), RESP (Breaths), NIBP (SYS, DIA, MEAN), SpO2 (Pulse rate, Saturation), Temperature, iBP, CO2 үздэг байх • Invasive цусны даралт хэмжигчтэй байх • Sidestream CO2 хэмжигчтэй байх • Эмнэлэгт ажиллаж байгаа төвийн хяналтын системд холбогдох боломжтой байх • Принтертэй байх /Цаасны олдоц сайн байх/ 		
2	Дохиолол: цахилгаан тэжээл, алдааны мессеж, бусад хэмжигдэхүүнүүдийн хязгаар хэтэрсэн тохиолдолд дуут болон дурс хэлбэрээр мэдэгддэг, Дохиоллын дууг ихэсгэж багасгах боломжтой, Дохиоллын гэрлэн индикатор зэрэгтэй байх Амьсгал: <ul style="list-style-type: none"> • Амьсгалын хэмжээ хязгаар: насанд хүрэгчид: 0-120 амьсгал/минут байх • хүүхэд/нэрай: 0-150 амьсгал/минут байх • Нарийвчлал: 1грм • Хурд: 3, 6.25, 12.5, 25, 50 мм/сек байх Температур: <ul style="list-style-type: none"> • Хязгаар: 0-50 °C • Нарийвчлал: ±0.1 °C 		

3	<p>ECG:</p> <ul style="list-style-type: none"> Холболт: 3/5 утас автоматаар илрүүлэх боломжтой байх /I, II, III, aVR, aVL, aVF, V/ Зүрхний хэмнэлийн хязгаар: /том хүнд 15-300 bpm, нярайд 15-350 bpm/ Нарийвчлал: 1bpm Ажиллагааны давтамжууд: Оношилгооны горим: 0.05-150 Гц Мониторын горим: 0.5-40 Гц Surgical горим: 1-20 Гц ST горим: 0.05-40 Гц <p>SPO2 хэмжилтийн утга: 0-100%</p> <ul style="list-style-type: none"> Хязгаар: (70-100%): Насанд хүрэгч/хүүхэд 2%, нярай 3% Нарийвчлал: 1% 		
4	<p>NIBP:</p> <ul style="list-style-type: none"> Хэмжилтийн хэлбэр: гар, автомат, үргэлжилсэн байх Хэмжилтийн хязгаар: Том хүн: SYS 25-290 mmHg, DIA 10-250 mmHg, MEAN 15-260 mmHg байх Хүүхэд: SYS 25-240 mmHg, DIA 10-200 mmHg, MEAN 15-215 mmHg байх Нярай: SYS 25-140 mmHg, DIA 10-115 mmHg, MEAN 15-125 mmHg байх <p>Sidestream CO2</p> <ul style="list-style-type: none"> Хязгаар: 0-20%, (0-152 mmHg байх) Нарийвчлал: ±0.1% (<1%), ±0.3% (5 - 6.9%), ±0.5% (12 - 12.9%) Урсгалын хурд: 90, 120 мл/мин 50 мл/мин (бага урсгал) Урсгалын нарийвчлал: ±15% буюу ±15 мл/мин байх AWRR хязгаар: 0 - 150 грм Apnea хугацаа: 10 с, 15 с, 20 с, 25 с, 30 с, 35 с, 40 с 		
5	<p>IBP</p> <ul style="list-style-type: none"> Суваг: 2 хүртэл сувагтай байх Хэмжилтийн хязгаар: -50 to 300 mmHg Нарийвчлал: ±2% or ±1 mmHg, Мэдрэмж: 5 V/V/mmHg Санах ой: өвчтөний NIBP Даралтын хэмжилт 1600, Events 1800, Долгионы мэдээлэл 1200 цагийн мэдээлэл хадгалах хүчин чадалтай байх Цахилгаан тэжээл: 100-240В, 50/60Гц байх Дахин цэнэглэгддэг батарейтай байх, /Батарейгаар тасралтгүй 4 цаг ажиллах боломжтой байх/ 		
6	<p>ТӨВИЙН ХЯНАЛТЫН МОНИТОРЫН СИСТЕМ (CMS)</p> <p>Шаардлагатай үзүүлэлт:</p> <p>Иж бүрдэл:</p> <ul style="list-style-type: none"> Дэлгэц: 1 ширхэг 1920*1080 нарийвчлалтай байх Процессор: i5-ийн 10-р үеээс дээш, Үйлдлийн систем: SSD-256Gb, мэдээлэл хадгалах: HDD-1TB байх Холболтын хэрэгслүүд WiFi(монитор нь wifi модультай байх), LAN утас, свич гэх мэт/ 		

7	<p>Программын үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> Хяналтын мониторуудын үзүүлэлтийг тусгай программын тусламжтай нэг болон хоёр дэлгэцэнд 64 хүртэлх сонголттойгоор дэлгэцэнд харуулах зориулалттай байна. <p>Хяналтын мониторын хувьд дараах үзүүлэлтүүдийг дэлгэцэнд гаргадаг байх</p> <ul style="list-style-type: none"> ○ Цусны даралт үзэх NIBP ○ Зүрхний бичлэг хянах ECG ○ Захын судасны хүчилтөрөгчийн хэмжээ хянах SpO2 ○ Температур °C ○ Амьсгалын тоо Resp ○ Судсан дахь даралт IVP ○ Нуурсхүчлийн хий үзэх CO2 <ul style="list-style-type: none"> • Амин үзүүлэлтүүдийн хэмжилтийг гараас хийх боломжтой байх • Амин үзүүлэлтүүдийн дохиоллын утгуудыг тохируулах боломжтой байх • Хэрэгцээт мэдээллүүдийг санах ойд хадгалах боломжтой байх • Хяналтын мониторт гарсан алдааг дуут дохиогоор болон гэрэл анивчиж мэдээлэх боломжтой байх • Сүлжээний принтертэй холбогдох боломжтой байх • Тухайн программыг өргөжүүлэх буюу эмнэлгийн бусад тасагт үзүүлэлтүүдийг гаргах, гар утсанд суургах боломжтой байх • Програм хангамж суулгах компьютер болон 1 ширхэг дэлгэц дагалдуулах 		
	Mindray -тай дүйцэхүйц байх		
8	Баталгаат хугацаа 2 ба түүнээс дээш жил		

3-2. Хяналтын монитор /энгийн/

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	<p>Шаардлагатай үзүүлэлт:</p> <ul style="list-style-type: none"> Дэлгэц: 12" болон түүнээс дээш 800x600 нарийвлалтай өнгөт TFT LCD дэлгэцтэй байх Дэлгэцэнд 8 хүртэлх долгионы мэдээллийг үзүүлдэг байх <p>Параметрын: ECG (HR), RESP (Breaths), NIBP (SYS, DIA, MEAN), SpO2 (Pulse rate, Saturation), Temperature, байх</p> <ul style="list-style-type: none"> Эмнэлэгт ашиглаж байгаа төвийн хяналтын системд холбогдох боломжтой байх 		

2	<p>Дохиолол: Цахилгаан тэжээл, алдааны мессеж, бусад хэмжигдхүүнүүдийн хязгаар хэтэрсэн тохиолдолд дуут болон дурс хэлбэрээр мэдэгддэг. Дохиоллын дууг ихэсгэж багасгах боломжтой. Дохиоллын гэрлэн индикатор зэрэгтэй байх</p> <p>Амьсгал:</p> <ul style="list-style-type: none"> Амьсгалын хэмжээ хязгаар: насанд хүргчид: 0-120 амьсгал/минут байх хүүхэд/нярай: 0-150 амьсгал/минут байх Нарийвчлал: 1грм Хурд: 3, 6.25, 12.5, 25, 50 мм/сек байх <p>Температур:</p> <ul style="list-style-type: none"> Хязгаар: 0-50 °C Нарийвчлал: ±0.1 °C <p>ECG:</p> <ul style="list-style-type: none"> Холболт: 3/5 утас автоматаар илрүүлэх боломжтой байх I, II, III, aVR, aVL, aVF, V/ Зүрхний хэмнэлийн хязгаар: /том хүнд 15-300 bpm, нярайд 15-350 bpm/ Нарийвчлал: 1bpm Ажиллагааны давтамжууд: Оношилгооны горим: 0.05-150 Гц Мониторын горим: 0.5-40 Гц Surgical горим: 1-20 Гц ST горим: 0.05-40 Гц 		
3	<p>SPO2 хэмжилтийн утга: 0-100%</p> <ul style="list-style-type: none"> Хязгаар: (70-100%): Насанд хүргч/хүүхэд 2%, нярай 3% Нарийвчлал: 1% <p>NIBP:</p> <ul style="list-style-type: none"> Хэмжилтийн хэлбэр: гар, автомат, үргэлжилсэн байх Хэмжилтийн хязгаар: Том хүн: SYS 25-290 mmHg, DIA 10-250 mmHg, MEAN 15-260 mmHg байх Хүүхэд: SYS 25-240 mmHg, DIA 10-200 mmHg, MEAN 15-215 mmHg байх Нярай: SYS 25-140 mmHg, DIA 10-115 mmHg, MEAN 15-125 mmHg байх <p>Санах ой: өвчтөний NIBP Даралтын хэмжилт 1600, Events 1800, Долгионы мэдээлэл 1200 цагийн мэдээлэл хадгалах хүчин чадалтай байх</p> <p>Цахилгаан тэжээл: 100-240В, 50/60Гц байх</p> <ul style="list-style-type: none"> Дахин цэнэглэгддэг батарейтай байх, /Батарейгаар тасралтгүй 4 цаг ажиллах боломжтой байх/ 		
4	<p>Дагалдах хэрэгсэл</p> <ul style="list-style-type: none"> 2ш Даралтын манжет 2ш SpO2 датчик 1ш ЭКГ кабель болон иж бүрэн электродууд Цахилгааны залгуур Батарей 		
	<p>Mindray ePM12 -тай дүйцэхүйц байх</p>		

5	Баталгаат хугацаа 2 жил ба түүнээс дээш жил		
---	--	--	--

4. Мэс заслын ор

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрэвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	<p>Шаардлагатай үзүүлэлт:</p> <p>Толгой , хүзүү, цээж хөвлийн хөндий , мөч болон бусад мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, урологи, чих хамар хоолой, тархины мэс засал болон бусад төрлийн мэс засал хийх зориулалттай, рентген нэвтрэх боломжтой тавцантай.</p>		
2	<p>Орны дээд хэсгийн хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> • Нийт урт: 2155 мм • Θргэн: 480 мм • Θргэн /орны хүрээний хамт/: 680мм <p>Хэсэг тус бүрийн хэмжээ</p> <ul style="list-style-type: none"> • Толгой хэсэг: 280x325мм • Нурууны хэсэг: 500x480мм • Суудлын хэсэг: 530x480мм • Гүяны хэсэг: 510x236мм • Хөлний хэсэг: 180x273мм • Беөрний хэсэг: 100x480мм <p>Шалнаас алслагдсан байдал</p> <ul style="list-style-type: none"> • Хамгийн холдоо: 1100мм • Хамгийн ойрдоо: 720мм 		
3	<p>Хөдлөх хязгаар</p> <ul style="list-style-type: none"> • Буцаасан хэлбийлт: $\geq 20^\circ$ • Хэлбийлт: $\geq 15^\circ$ • Хажуу тийш хазайлгах: $\geq 15^\circ$ <p>Хэсгүүдийн хөдөлгөөн</p> <ul style="list-style-type: none"> • Толгойн хэсгийг өргөх: $\geq 45^\circ$ • Толгойн хэсгийг налуулах: $\geq 90^\circ$ • Хөлийн хэсгийг буулгах: $\geq 90^\circ$ • Хөлийн хэсэг онгойх: $\geq 90^\circ$ • Нурууны хэсгийг дээш өргөх: $\geq 45^\circ$ • Нурууны хэсгийг хойш налуулах: $\geq 20^\circ$ • Θөвгэнд дэмжилгээ үзүүлэгчийг өргөх: $\geq 100\text{мм}$ 		
4	<p>Даацын ачаалал: 250кг</p> <p>Тоормосны эсэргүүцэл: 150Н баггүй байх</p> <p>Цахилгаан: 220В, 50Гц</p> <p>Дотоод цахилгаан эх үүсвэр: $\geq 2,4 \text{ АН}$</p> <p>Бүтээгдэхүүний аюулгүй байдлын ангилал: IB</p>		
5	<p>Дагалдах хэрэгсэл:</p> <ul style="list-style-type: none"> • Толгойн хэсэг 		

	<ul style="list-style-type: none"> Дуслын өлгүүр Биед дэмжлэг үзүүлэгч-Хатуу байрлалд 2 талаас тулж бэхлэх тулаас бэхэлгээ Мөрөнд дэмжлэг үзүүлэгч Гарын тавиур Өвдгэнд дэмжлэг үзүүлэгч Зөөлөвч /матрос/ Хөлийн хэсэг Тусгаарлагч Бариул нэмэлт тулгуур бэхэлгээнүүдийг дагалдуулах. 		
6	Баталгаат хугацаа: 2 ба түүнээс дээш жил		

5. Микроскоп

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	<p>Шаардлагатай үзүүлэлт: Гэмтлийн мэс заслын хамгийн түгээмэл хэрэглээний дараах мэс заслыг хийх боломжтой байх.</p> <ol style="list-style-type: none"> Гар болон дээд мөчний мэс засал Гавлын мэс засал, нүүрний гэмтлийн нөхөн сэргээлт Нүүрний суулгацын мэс засал Уруул тагнайн сэтэрхий зэрэг төрөлхийн гажиг засах Түлэнхийн дараах нөхөн сэргээх мэс засал Дээжний булчирхайн бүтцийг багтаасан денатурацийн мэс засал <p>Энэхүү ортопедийн мэс заслын микроскоп нь 30-90 градусын хазайлттай дуран хоолой, 55-75 хүүхэн харааны зайны тохируулга, нэмэх эсвэл хасах 6D диоптийн тохируулга, хөлийн товчлуурын цахилгаан удирдлагатай тасралтгүй томруулалт, гадаад CCD зургийн системээр нэг товшилтоор видео бичлэг хийх, дэлгэцийг дэмждэг. зураг үзэх, тоглуулах боломжтой байх. 2 Галоген гэрлийн эх үүсвэрүүд нь хангалттай гэрэл гэгээтэй, найдвартай нөөцлөлтийг хангаж чаддаг байх.</p>		
2	Аппаратны бүрэлдэхүүн хэсгүүд: <ul style="list-style-type: none"> Microscope CCD Camera system Henon Lamp Objective lens 		
3	<p>Нүдний шил:</p> <p>12.5x томруулах, хүүхэн харааны зайг тохируулах боломжтой хүрээ 55мм~75мм, диоптри тохируулах хүрээ +6D ~ -6D. Хоёрдахь объектын линзний фокус 180 мм</p>		
4	Дуран хоолой:		

	<p>0°~90° хувьсах өнцгийн дуран хоолой, шинэ хүүхэн харааны зайны тохируулга нэмнэ</p> <p>Томруулах:</p> <p>6:1 томруулалт, моторжуулсан, 4.5x~27.3x томруулалт; харах талбар Φ44~Φ7.7мм</p> <p>Коаксиаль туслахын дуран хоолой</p> <p>Гарын авлагын 3 шаттай солигч, нийт өсгөлт 6.5x, 10.8x, 17.3x; харах талбар Φ30.5мм, Φ18.3мм, Φ11.4мм</p> <p>Коаксиаль гэрэлтүүлэг:</p> <p>Гэрлийн цэгийн гэрэлтүүлгийн диаметр Φ50мм, гэрэлтүүлгийн эрчим 100000люкс</p>		
5	<p>Зорилго: f175мм (200мм, 250мм гэх мэт)</p> <p>Фокус: мотортой, хүрээ +/-25мм, хурд 33с/бүх зай</p> <p>X-Y орчуулагч: мотортой X-Y чиглэлд хөдөлж, +/-30 мм-ийн хүрээтай</p> <p>Гарны хамгийн их урт: 1200 мм</p> <p>Зогсоол: зөөгч гарны дүүжин өнцөг 0 ~ 300° объектоос шал хүртэлх өндөр 800мм<Н<1250мм.</p> <p>Усны хамгаалалттай, 8 функцтэй хөл шилжүүлэгч алхамуудтай</p> <ul style="list-style-type: none"> ISO 9001:2000 and ISO 13485 :2003 олон улсын чанарын шаардлага хангасан байх Нэгэн зэрэг эмч туслах эмчтэй хамтран ажиллах боломжтой Face to face урд урдаас хардаг байх Хүргэлт суурьлуулалт үнэнд багтсан байх Дагалдах бичиг баримт бүрэн байх 		
6	Microscope ASOM4 марктай дүйцэхүйц байх		
7	Баталгаат хугацаа: 2 ба түүнээс дээш жил		

6. Каогуляци

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг номлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Зориулалт: Мэс заслын үед хэт өндөр давтамжийн цахилгаан гүйдлээр бие махбодийн эдийг түлэх зүсэх зориулалттай.		
2	Шаардлагатай үзүүлэлт: <ul style="list-style-type: none"> Идэвхгүй электродын холболтыг автоматаар шалгана. Асааж унтраахад сүүлчийн ажиллаж байсан нөхцөл хадгалдаг байх. 		

	<ul style="list-style-type: none"> Гар болон хөл унтраалгаар хялбар удирдагдана. Гар биполяр горим / автомат биполяр горим ажиллагааны явцад зөвхөн хамсаагаар хүрнэ/ Хэт өндөр хүчдэлээс хамгаалсан гал хамгаалгачтай. Нейтрал электрод нь төхөөрөмжөөс хөндийрсөн үед дохиолол дуугарч ЛЕД гарэл асах. Горим тус бүр дээр өөр өөр дохиолол дуугарч, өөр гэрэл асдаг байх. Өвчтөний бие болон идэвхгүй электрод хөндийрсөн үед өндөр давтамжийн цахилгааныг автоматаар блоклдог байх. 100 хэрэглэгчийн тохиргоог хадгалах санах ойтой. Биполяр зүсэлт 		
3	<ul style="list-style-type: none"> Хүчдэл: AC 120V/230V Давтамж: 50Гц/60Гц Цахилгааны хэрэглээ: 1200Вт±10%, 1100Вт±10% Гал хамгаалгач: T10A AC120B, 6.3A AC230B Хамгаалалтын ангилал: Ангилал I , төрөл CF Гүйдлийн ангилал: IEC 601, PART2-2 Ажиллагааны давтамж: 400кГц, 500 кГц Хэмжээ: 300мм*455мм*150мм Жин: 13кг 		
4	<p>Орчны нөхцөл</p> <ol style="list-style-type: none"> Ажиллагааны температур: 10°С- 40°С Хадгалах температур: -10°С- 60°С Чийгшил: 20%-95% Ажиллагааны дараалт: 700мбар-1060мбар Ажиллагааны цикл: 10сек-30сек Хөргөлт: Дотоод сэнс 		
5	<p>Стандарт хэрэгслүүд:</p> <ol style="list-style-type: none"> Давхар хөл шилжүүлэгч Хос товчлуурын бариул Хоёр түйт хамсаа Электрод Идвэхгүй электрод Нэг удаагын идвэхгүй электрод Bipolar кабель Монополяр бариул Ганц хөл шилжүүлэгч 		
6	<p>Нэмэлт хэрэгслүүд</p> <p>F1 Straight 9.0cm 0.5 Tip F2 Angled 9.0cm 0.5 Tip F3 Straight 12.1cm 1.0 Tip F4 Straight 17.8cm 1.0 Tip F5 Angled 17.8cm 1.0 Tip F6 Bayonet 15.2cm 1.0 Tip • Дугуйтай суурьтай байх.</p>		
7	DOCTANZ 400 марктай дүйцэхүйц байх.		
8	Баталгаат хугацаа: 2 ба түүнээс дээш жил		

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, төндөрт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)	6
1	2	3	4	5			7
Багц №1							
1	Зөөврийн диализын аппарат, ус цэвэршүүлэх аппаратын хамт		1	КОМ	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
Багц №2							
1	Үнтуулгын аппарат	2		КОМ	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	
Багц №3							

1	Хяналтын монитор WiFi, +central system	10	КОМ	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	
2	Хяналтын монитор	10	КОМ	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	
Багц№4						
1	Мэс заслын оп	2	Ш	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	
Багц№5						
1	Микроскоп	1	КОМ	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	
Багц№6						
1	Каогуляци	3	Ш	Гэмтэл согог судлалын үндэсний төв	2024.06.20-2024.07.31	

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1. Тендер илгээх маягт

Маягт 2. Барааны үнийн задаргаа

Маягт 3. Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ²	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³
1										Tийм/Үгүй
2										
...										
								Тендерийн нийт үнэ		

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5

Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 6

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
- 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
- 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
- 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
- 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
- 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
- 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
- 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
- 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

	<p>харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхуй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.</p>
Гэрээний тайлбар	<p>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
Бараа нийлүүлэх	<p>ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ</p> <p>2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.</p> <p>2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй</p>

	шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
	2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
	2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
Бараа нийлүүлэх газар	2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
	2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
	2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
	2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
	2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
	2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
Барааг хүлээлгэн өгөх	2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
	2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Барааны гарал үүслийн улс	2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
	2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Баглаа боодол	2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.
	2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

	2.16	Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.17	Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
	2.18	ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
Гүйцэтгэлийн баталгаа	2.19	Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн З хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
	2.20	Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:
	2.20.1	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
	2.20.2	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
	2.20.3	Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
	2.21	Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
	2.22	ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
	2.23	Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.
	ГУРАВ. ЗАХИАЛАГЧ	
Барааг хүлээн авах	3.1	Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2	Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3	Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

- 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

- 3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх
эрсдэл

- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
 - 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаarahгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

Даатгал

- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын

	гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
Доголдол	<p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p> <p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> <p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p>
Чанарын баталгаа	<p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгүй тохиолдолд хугацаа</p>
Алданги	7

	хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.		
Оюуны өмчийн эрх зөрчих	4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.		
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.	4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.	
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.	4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.	4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.	4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.	

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

	5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
	5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

- 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
- 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
- 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.
- 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
- 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
- ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**
- Төлөөлөгч
- 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
- 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
- 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Туслан гүйцэтгэгч
- 6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын догоилдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.
- Нууцлал
- 6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал

	зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
Мэдэгдэл	<p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> <p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2. үнийн тохируулга хийсэн.</p> <p>6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p> <p>6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрлөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	
Маргаан шийдвэрлэх	

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	<p>Бараа нийлүүлэх газар:</p> <p><i>Гэмтэл согог судлалын үндэсний төвийн байр</i></p> <p>Тухайн тоног төхөөрөмжийг суурилуулах тасаг, нэгжид суурилуулан тохируулан ажиллуулж хүлээлгэн өгнө.</p>
ГЕН 2.6.	<p>Бараа нийлүүлэх хугацаа: 2024 оны 06 сарын 20-нээс 2024 оны 07 сарын 31-ны өдөр хүртэл</p> <p>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: байхгүй.</p> <p>Гэрээ нь 2026 оны 07 сарын 31-ны өдөр хүртэл хүчинтэй.</p>
ГЕН 2.10.	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p><i>Тоног төхөөрөмжийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн байранд хүргэж, баглаа боодлыг задлан угсарч суурилуулж, тохируулан ажиллуулж хүлээлгэн өгнө.</i></p> <p><i>Тээвэрлэх, суурилуулах, тохируулах явцад гарсан зардлыг нийлүүлэгч хариуцах ба гэмтсэн барааг буцаан сольж өгнө.</i></p> <p>Бараанд холбогдох баримт бичиг: Зарлагын баримт, тоног төхөөрөмж хүлээлцсэн акт, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын техникийн комиссын урьдчилсан дүгнэлт</p> <p>Угсралт, суурилуулах: <i>угсарч суурилуулж, тохируулан ажиллуулна.</i></p>
ГЕН 2.14.	<p>Баглаа, боодол:</p> <p><i>Гэмтэл согог судлалын үндэсний төвийн байр, 1-р давхар, Агуулах, зарлагын баримт, акт, зөвшөөрөл, бусад дагалдах баримтын хамт</i></p> <p>Баглаа, боодлын шаардлага:</p> <p><i>Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна.</i></p>
ГЕН 2.17.	<p>Худалдааны нөхцөл:</p> <p>“Incoterms 2020” DDP гарах бүх зардлыг нийлүүлэгч тал хариуцана.</p>
ГЕН 2.19	100 саяас дээш дүнтэй гэрээ байгуулах эрх олгогдсон нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийхгүй.
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр]</p> <p>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: <i>Тоног төхөөрөмжийг нийлүүлж дагалдах үйлчилгээг бүрэн хийсний дараа нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан акт, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын техникийн комиссын урьдчилсан дүгнэлт зэргийг үндэслэн</i></p>

	<i>төлнө. Чанарын баталгаа болох гэрээний үнийн дүнгийн 5 хувийг гэрээний дүнгээс хасч шилжүүлнэ.</i>
ГЕН 3.12.	Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
ГЕН 4.2.	Даатгал: <i>Даатгалын хураамжийг нийлүүлэгч хариуцана.</i>
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: 2 ба түүнээс дээш жил <i>[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол тендер шалгаруулалтын баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих]</i>
ГЕН 4.11	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <i>Чанарын баталгаа шаардана</i> <i>Чанарын баталгаа шаардах бол,</i> Чанарын баталгааны дүн: <i>Гэрээний үнийн дүнгийн 5 хувь</i> <i>Чанарын баталгааны хугацаа -1жил</i>
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “ <i>Тийм</i> ”, Алдангийн хувь: <i>хоног тутамд 0.1 хүртэл хувиар</i>
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “ <i>Үгүй</i> ”

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

2024 оны сарын ний өдөр

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дунг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.05.09**

Тендер шалгаруулалтын төрөл: Бараа

Тендер шалгаруулалтын нэр: **Мэс заслын тоног төхөөрөмж худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ГССҮТ/20240202015**
Нийт төсөвт өртөг: **792,000,000**

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

- Гэмтэл согог судлалын үндэсний төв** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Тийм”**
Багц № 1: Зөөврийн диализын аппарат, ус цэвэршүүлэгч аппаратын хамт
Багц № 2: Унтуулгын аппарат
Багц № 3: Өвчтөний хяналтын монитор
Багц № 4: Мэс заслын ор
Багц №5: Микроскоп
Багц №6: Коагуляци
Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах бараа: **байхгүй**
- Тендерийг **2024 оны 05 сарын 31-ний өдрийн 14 цаг 00 минут-аас өмнө** тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба **2024 оны 05 сарын 31-ны өдрийн, 14 цаг 30 минут-т** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
- Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Тийм”**
Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх **“Үзүй”**
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үзүй”**
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснээр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

1 давхар, Санхүү бүртгэлийн алба 135 тоот

Утасны дугаар: **факс-70180136, 99167515, 89999574**

Цахим шуудангийн хаяг: **ntorc@gemtel.mn**, вэб хуудас: **gemtel.mn**